

Зам, тээврийн хөгжлийн сайдын  
..... оны .... дугаар сарын ... -ны өдрийн  
..... тоот тушаалын хавсралт

## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД ТАВИГДАХ НЭМЭЛТ ШААРДЛАГА

## **НЭГ. Тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах ерөнхий шаардлага**

1.1. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байна.

1.2. Тусгай зөвшөөрөл хүсэгч нь эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамаарч инженер техникийн ажилтан болон холбогдох мэргэжлийн Зөвлөх болон Мэргэшсэн инженерийн зэрэгтэй ажилчидтай байна. Зөвлөх инженерийн зэрэгтэй ажилтан нь 3 хүртэл хуулийн этгээдэд зөвлөж болно.

1.3. Инженер, техникийн ажилтан нь тусгай зөвшөөрөл хүсэгчийн үндсэн ажилтан байна.

1.3.1 Мэргэжлийн дипломын хуулбар

1.3.2 Нийгмийн даатгалын лавлагаа

1.3.3 Баталгаажсан нийгмийн даатгалын тайланг НД-7 болон НД-8 маягтын дагуу

1.4. Тусгай зөвшөөрөл хүсэгч гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн инженер техникийн ажилчдын 60-аас доошгүй хувь нь дотоодын инженер техникийн ажиллагсад байна.

1.5. Машин механизм, тоног төхөөрөмж нь тухайн ажлыг гүйцэтгэхэд технологийн бүрдэл, тоо хэмжээ, ашиглалтын шаардлага хангасан байхын зэрэгцээ тусгай зөвшөөрөл хүсэж байгаа тухайн хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй өөрийн өмчлөлийн машин механизм, тоног төхөөрөмжтэй байна.

1.5.1 АТҮТ-ын лавлагаа

1.6. Машин механизм, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг Тусгай зөвшөөрлийг олгоход тавигдах шаардлагад заасны дагуу түрээслэн ажиллуулж болох ба энэ тохиолдолд түрээсийн гэрээ байгуулсан байна.

1.6.1 Нотариатаар баталгаажуулсан түрээсийн гэрээг хавсаргах

1.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 2 дахь заалтын дагуу зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногоос доошгүй хугацааны өмнө хугацаа сунгуулах тухай өргөдөл, хуульд болон энэ тусгай нөхцөл, шаардлагын дагуу бүрдүүлсэн баримт бичгийн хамт эрх бүхий этгээдэд цахим системээр дамжуулан гаргана.

1.8 Хүсэлтэд ерөнхий болон тусгай шаардлагаас гадна нэмэлтээр доорх мэдээлийг ирүүлнэ.

1.8.1 Тусгай зөвшөөрлийн хүрээнд хийсэн ажлын мэдээллийг ажил гүйцэтгэх гэрээ, акт, бусад нотлох баримтын хуулбарын хамт

1.8.2 Үндсэн хөрөнгийн болон санхүүгийн тайлан

1.9 Тусгай зөвшөөрөлд үндэслэн ангилал нэмж зөвшөөрөл авсан тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацаа өөрчлөгдөхгүй.

1.10 Эрх бүхий этгээд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ангилал нэмж авах зөвшөөрөл хүссэн өргөдөлд тусгай зөвшөөрлийг авахад бүрдүүлсэн баримт бичгийг дахин шаардахгүй буюу зөвхөн нэмэлт зөвшөөрөлд шаардлагатай материалыг ирүүлнэ.

**ХОЁР. Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах тусгай зөвшөөрөл олгоход тавигдах тусгай шаардлага**

Ажилбар	Шаардлагатай инженер-техникийн ажилтан	Шалгуур үзүүлэлт
5.2.1. Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах	Авто замын инженер-1	Авто замын инженер мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай.
	Гүүрийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 6 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай.
	Хэмжилтийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 8 жилийн ажлын туршлагатай үүнээс 5 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багажнуудыг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
	Инженер-эдийн засагч-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд төсөвчнөөр ажилласан байх. (Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно)
<b>Шаардлагатай тоног төхөөрөмж</b>		Компьютер, тоног төхөөрөмж, Програм хангамж, Нивелир, теодолит гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайгуулын ажлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм үнэлгээ, төсөв зохиох програм хангамжтай байх.

**ГУРАВ. Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл олгоход тавигдах тусгай шаардлага**

Ажилбар	Шаардлагатай инженер-техникийн ажилтан	Шалгуур үзүүлэлт
5.2.2. Зураг төсөл боловсруулах	Авто замын инженер-2	Аль нэг авто замын инженер нь тухайн мэргэжлээрээ 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 10 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай.
	Гүүрийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх болон мэргэшсэн зэрэгтэй байх шаардлагатай.
	Хэмжилтийн инженер-1	Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшдэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
	Материалын инженер-1	Тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. (Энэ чиглэлээр мэргэшсэн авто замын инженер байж болно.)
	Төсөвчин-1	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх. (Энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно.)
	Зургийн техникч - 3	Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 1 жилд нь замын хайгуул, зураг төсөл дээр ажилласан байх.
<b>Шаардлагатай тоног төхөөрөмж</b>		Компьютер, тоног төхөөрөмж, Програм хангамж, Нивелир, теодолит гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайгуулын ажлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм үнэлгээ, төсөв зохиох програм хангамжтай байх.

**ДӨРӨВ. Авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл олгоход тавигдах тусгай шаардлага**

Нийтлэг нөхцөл шаардлага: Ажлын туршлагатай байх /хүснэгтэнд зааснаар/

Д/Д	Нэрс ба хүчин чадал	Зөвшөөрөл авах ажлын төрөл		
		5.2.3 Авто зам, замын байгууламжийг барих	5.2.4 Авто зам, замын байгууламжийг засварлах	5.2.5 Авто зам, замын байгууламжийг арчлах
		Бүх төрлийн асфальтбетон, цементбетон, хөнгөвчилсэн хучилттай авто зам, замын байгууламжийг барих (Их засвар, шинэчлэлт)	Бүх төрлийн асфальтбетон, цементбетон, хөнгөвчилсэн хучилттай авто зам, замын байгууламж, түүний ээлжит болон урсгал засвар	Бүх төрлийн асфальтбетон, цементбетон, хөнгөвчилсэн хучилттай авто зам, замын байгууламжийн арчлалт, урсгал засвар, талбайн тохижилт, тэмдэг, тэмдэглэгээний ажил
<b>А.</b>	<b>Зөвшөөрөл авахад шаардагдах технологийн зориулалттай машин механизм заасан тоогоор (Хамгийн багадаа)</b>			
1	Эксковатор /0.65м <sup>3</sup> /	2	1	
2	Автогрейдер /250м.х/	1	1	
3	Ачигч /1.0м <sup>3</sup> /	3	1	1
4	Доргиурт индүү /16 тн-оос дээш/	2		
5	Хийн дугуйт индүү /10 тн/	1	-	
6	Асфальтны индүү /6тн-оос дээш	1	1	1
7	Автогудронатор /3.5 м/	1	1	
8	Өөрөө буулгагч	8 (50 хувь нь түрээс байж болно)	2	1
1	Усны машин	2	1	
10	Асфальт дэвсэгч	1 (Түрээс байж болно)	-	-
11	Авто кран /25 тн-үүс дээш/	1		
12	Шигшүүртэй чулуу бутлуур	1 (Түрээс байж болно)		
13	Асфальтобетон заваод /80 тн/цаг/	1 (Түрээс байж болно)	1 бага оврын (Түрээс байж болно)	
14	Лаборатор/иж бүрэн/	1	1 (Түрээс байж болно)	1 (Түрээс байж болно)
15	Геодезийн иж бүрдэл	1	1 (Түрээс байж болно)	1 (Түрээс байж болно)
16	Бетон узель	1	1 (Түрээс байж болно)	
17	Тэмдэглэгээний машин, тоног төхөөрөмж	1	1	1
18	Авто замын арчлалтын цас цэвэрлэгч машин			1
<b>Зөвшөөрөл авахад шаардагдах мэргэжлийн ИТА-ын хамгийн бага тоогоор</b>				
18	Ерөнхий инженер	1	1	
19	Авто замын инженер	2*	1	1
20	Гүүр, хиймэл	2*		

	байгууламжийн инженер			
21	Геодезийн инженер	1		
22	Материалын инженер	2*	1	1
<b>Б.</b>	<b>Зэрэг дэвийн нэмэлт тайлбар</b>			
1.	Нэмэлт тайлбар: Авто замын мэргэшсэн инженерийг материал, геодезийн инженер тооцож болно. Авто замын инженерийг гүүрийн барилгын ажлын туршлагыг үндэслэн гүүрийн инженерт тооцож болно. * Аль нэг нь гэрээт байж болно.	Ерөнхий инженер нь 8 жилийн ажлын туршлагатай зөвлөх буюу мэргэшсэн зэрэгтэй байх, Гүүр, хиймэл байгууламж, авто замын инженерүүд 5 жилийн ажлын туршлагатай мэргэшсэн зэрэгтэй байх, бусад инженерүүд ажлын 3-5 жилийн туршлагатай байх.	Ерөнхий инженер нь 5 жилийн авто замын ажлын туршлагатай бусад инженерүүд ажлын туршлагатай байх	Авто замын инженер нь 3 жилийн авто замын ажлын туршлагатай бусад инженерүүд ажлын туршлагатай байх

**ТАВ. Техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл олгоход тавигдах тусгай шаардлага**

5.2.6 Авто зам, замын байгууламжийг барих, засварлахад Техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх	Ерөнхий инженер	Зам барилгын ажилд 15 жил, үүнээс 10-аас доошгүй жил зураг төслийн болон хяналтаар ажилласан, хяналтын инженерийн тэргүүн зэрэгтэй, зөвлөх болон мэргэшсэн инженер байх
	Замын инженер-2	Зам барилгын 10 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтанд ажилласан, авто замын инженерийн мэргэжилтэй байх. Аль нэг инженер нь мэргэшсэн, хяналтын ахлах инженерийн зэрэгтэй байх.
	Гүүрийн инженер-1	Зам барилгын чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтанд ажилласан, гүүрийн инженерийн мэргэжилтэй, мэргэшсэн, хяналтын ахлах инженерийн зэрэгтэй байх.
	Материалын инженер-2	Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтаар ажилласан, хяналтын ажлын туршлагатай, зам, гүүрийн инженерийн мэргэжилтэй мэргэшсэн, хяналтын ахлах инженерийн зэрэгтэй байх эсвэл дээрхи шаардлагыг хангасан барилгын материалын инженер мэргэшсэн, хяналтын ахлах инженер байх.
	Тоо хэмжээний инженер-1	Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтанд ажилласан, хяналтын ажлын туршлагатай, зам, гүүрийн инженерийн мэргэжилтэй, мэргэшсэн төсөвчин, инженер байх.
	Хэмжилтийн инженер-1	Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтанд ажилласан, хяналтын ажлын туршлагатай, зам, гүүрийн инженер, мэргэшсэн, хяналтын ахлах инженерийн зэрэгтэй байх эсвэл геодезийн инженер мэргэшсэн, хяналтын ахлах инженерийн зэрэгтэй байх.
<b>Шаардлагатай тоног төхөөрөмж</b>		Компьютер, тоног төхөөрөмж, Програм хангамж, Нивелир, теодолит гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайгуулын ажлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм үнэлгээ, төсөв зохиох программ хангамжтай байх.

### **Зургаа. Бусад**

6.1 Тусгай зөвшөөрлийн материалыг хуурамчаар үйлдсэн бол Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2 Тусгай зөвшөөрөл олгоход Улсын Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасныг баримтлан аж ахуйн нэгжээс тэмдэгтийн хураамж авч, улсын төсөвт шилжүүлнэ.

6.3 Энэхүү батлагдсан шаардлагад тусгагдаагүй асуудлыг Авто замын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

----oOo----